




# ДАМЖУУЛАХ Сүлжээ

ЦДҮС ТӨХК-ИЙН ХЭВЛЭЛ  
www.transco.mn



№05 (143) 2019 оны 09 сар

## ТӨРИЙН ДЭЭД ОДОН, МЕДАЛИАР ШАГНАГДЛАА

Монголын тулгар төрийн 2228, Их Монгол Улс байгуулагдсаны 813, Ардын хувьсгалын 98 жилийн ойн үндэсний их баяр наадмаар Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигаар эрчим хүчний салбарт олон жил, тасралтгүй, үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан компанийн Хангайн бүсийн салбарын засварын монтер Д.Батбаяр, ахмад ажилтан О.Алтанцэцэг, Б.Баянжаргал нар "Алтангадас одон"-оор, Төвийн бүсийн салбарын сургалт, бүтээмжийн инженер Н.Эрдэнэчимэг, Зүүн-Өмнөд бүсийн салбарын ээлжийн инженер С.Баярмаа нар "Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар шагнагдлаа.

Төрийн дээд одон, медалиар шагнагдсан ажилтнууддаа баяр хүргэж, энгэртээ зүүсэн одон шигээ үргэлж гялалзаж явахын ерөөлийг өргөн дэвшүүлье.

ЗУХ-ийн мэргэжилтэн Т.Аюуш



Гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу ХБС-т албан томилолтоор ажиллах үеэр шаганлыг гардуулав



Ахмад настан О.Алтанцэцэг

### НҮҮР-2

КОМПАНИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ,  
ТЕХНИКИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ХУРАЛ БОЛОВ

### НҮҮР-9

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ АЛБАН  
ТОМИЛОЛТООР ДЭД СТАНЦУУДАД  
АЖИЛЛАЛАА

### НҮҮР-10

«ЭРЧИМ ХҮЧНИЙ АЖИЛТНЫ ӨДӨР»-  
ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ

### НҮҮР-11


МОНГОЛ УЛСЫН АЖ  
ҮЙЛДВЭРИЙН ГАВЬЯАТ  
АЖИЛТАН Н.ТОГООН ХӨШӨӨНД  
ЦЭЦЭГ ӨРГӨВ



ЗӨБС-ын ээлжийн инженер С.Баярмаа



ТБС-ын сургалт, бүтээмжийн инженер Н.Эрдэнэчимэг



# БНХАУ-Д АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛЛАВ

БНХАУ-ын Өвөр Монголын эрчим хүчний олон улсын хамтын ажиллагааны компани /ӨМЭХОУХАК/, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК, Оюутолгой ХХК-ийн төлөөлөл оролцсон уулзалт хэлэлцээ 2019 оны 07 дугаар сарын 04, 05-ны өдрүүдэд БНХАУ-ын Хөх хотод зохион байгуулагдав.



Уг уулзалтын үеэр БНХАУ болон Монгол Улсын эрчим хүчний салбар дахь харилцан ашигтай хамтын ажиллагаа, түншлэлийн харилцааг цаашид улам гүйнзгийрүүлж, өмнөх онуудад байгуулсан "Санамж бичиг"-т тусгасан харилцан ойлголцлын хүрээг өргөжүүлэх, Оюутолгой ХХК-иас хэрэгжүүлж байгаа техник зохион байгуулалтын арга хэмжээнд Хятадын талын оролцоог тодотгох асуудлыг хэлэлцэв.

Г.Түвшин



## КОМПАНИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНИКИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ БОЛОВ

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Үйлдвэрлэл, техникийн зөвлөлийн 2019 оны 2 дугаар улирлын хурал 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдөр болж, хурлаар компанийн 2019 оны өвлийн их ачааллын горим ажиллагааны схем, 2019 оны их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын тодотгосон төлөвлөгөөний төсөл зэрэг нийт 19 асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргав.

ТБТХ-ийн ахлах бөгөөд ашиглалтын инженер  
Б.Энхбат



# ХАНГАЙН БҮСИЙН САЛБАРЫН 2018 ОНЫ “ШИЛДЭГ АЖИЛ”

## 1. 220/110/35/6 КВ-ЫН ЭРДЭНЭТ ДЭД СТАНЦАД ТЕХНИКИЙН ШИНЭЧЛЭЛ ХИЙВ

Эрдэнэт дэд станц 1978 онд баригдахад суурилуулсан РНДЗ-220 маркийн 6 ком хуурай салгуурыг Швед улсын АВВ компанид үйлдвэрлэсэн, алсын удирдлага бүхий GW55-252D маркийн хуурай салгуур шинээр сольж суурилуулснаар цахилгаан эрчим хүчийг тасралтгүй найдвартай дамжуулахад чухал үүрэг гүйцэтгэх юм.



## 2. АВААРЫГ БОГИНО ХУГАЦААНД УСТГАВ

Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр Булган-Хархорины 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын 9 ширхэг тулгуур унаж Өвөрхангай, Архангай, Баянхонгор зэрэг 9 аймгийн 69 сумд цахилгаангүй болсон системийн хэмжээний томоохон аваар гарсаныг компанийн нийт 87 ажилтан богино хугацаанд сэргээн босгож, хэвийн үйл ажиллагааг хангасан.



## 3. ХЯНАЛТ УДИРДЛАГЫН СИСТЕМД БҮРЭН ШИЛЖИВ

Эрчим хүчний үйлдвэрлэлт, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааны үйлдвэрлэлийн автоматжуулалт, мэдээллийн хяналт удирдлагыг цогц системд бүрэн шилжүүлэх Эрчим хүчний яамны зорилтын хүрээнд Хангайн бүсийн салбарын төвийн ажлын байрууд, Эрдэнэт, Булган, Мөрөн, Баянхонгор, Арвайхээр, Цэцэрлэг, Хархорин дэд станцуудыг бүрэн камержуулсан.



## 4. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАНХИМЫГ ШИНЭЭР ТОХИЖУУЛАВ

Салбарын ажилтнуудын аюулгүй ажиллах, хандлагыг өөрчлөх улмаар зөв дадал хэвшилд сургах зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн танхимыг шинээр тохижуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн “Орон тооны бус зөвлөл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлсэн. Мөн Хангайн бүсийн салбар болон Төвийн бүсийн салбарын анхны нөхөрлөлүүдийн бүрэлдхүүний бэлэн байдлыг хангах, болзошгүй гамшгийн үед ажиллах ур чадвар, амилуулах суурь тусламж үзүүлэх, багаар ажиллах арга барилыг эзэмшүүлэх, харилцан туршлага солилцох “Аврагч-2018” тэмцээнд амжилттай оролцов.



## 5. “ТУРШИЛТЫН ЛАБОРАТОРИ”-ТОЙ БОЛОВ

Реле хамгаалалт автоматик, хэмжилт, туршилтын албаны ажилтнууд дотоод нөөц бололцоогоо ашиглан өндөр хүчдэлийн норм, зай хэмжээг хангасан Реле хамгаалалт автоматик, хэмжилт туршилтын лабораторийг шинээр тохижуулснаар ажилтнуудын аюулгүй ажиллагааг хангасан ажил болсон.



## 6. ПАРК ШИНЭЧЛЭЛТ ХИЙВ

Тус салбарт ашиглагдаж байсан ашиглалтын норм дууссан автомашин механизмуудыг Зил-131 МТО, Hyundai super areo city автобус, XNW51360 маркийн эксковатороор сольж, парк шинэчлэлт хийлээ. Эдгээр тусгай зориулалтын автомашинтай болсноор салбарын үндсэн үйл ажиллагааны чанар дээшилж, цахилгаан эрчим хүчийг хэрэглэгчдэд тасралтгүй, найдвартай дамжуулах үүргээ амжилттай хэрэгжүүлэх, боломж нөхцөлийг хангаж байгаагийн нэг том илрэл юм.



## 7. ШИНЭ ТӨХӨӨРӨМЖ СУУРИЛУУЛАВ

110/10 кВ-ын Хялганат дэд станцад GZDW-40Ah/100V маркийн тогтмол гүйдлийн панелийг суурилуулж, микропроцессорт реле шалгах “PONOVO” төхөөрөмжтэй болсон.




## 8. АВААРЫГ УСТГАХАД МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭВ

Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр Баруун бүсийн эрчим хүчний системд гарсан аваарыг устгахад Хангайн бүсийн салбарын засварын албаны ажилтнууд мэргэжлийн тусалцаа үзүүлсэн.



## 9. ДСУМС ПРОГРАММЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЛЭВ


Дамжуулах сүлжээний удирдлага мэдээллийн систем программыг салбарын үйл ажиллагаанд нэвтрүүлснээр хяналт, мэдээлэлийн нэгдсэн баазтай болох, өдөр тутмын үйл ажиллагааг хянахад түлхэц болох юм.



## 10. ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА БОЛОВ

Хангайн бүсийн салбар Орхон аймгийн “Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэгч байгууллага”-аар шалгарсан.





## УЛААНБААТАР САЛБАР

## ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах, цахилгаан дамжуулах агаарын шугамын найдвартай ажиллагааг хангах зорилгоор Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Баянгол дүүргийн Замын цагдаагийн хэлтэс, Баянгол дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтэстэй хамтран 110 кВ-ын 109, 110 дугаар цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын зурваст зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан аж ахуйн нэгж, хүнд даацын автомашинуудыг шилжүүлж, хамгаалалтын зурвасыг чөлөөлөх, 150 метр хашааг өөрсдийн хүчээр барих ажлыг 2019 оны 08 дугаар сарын 15, 27-ны өдрүүдэд зохион байгуулсан.



“Эрчим хүчний тухай хууль”, “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор 220 кВ-ын 205,

206, 208, 110 кВ-ын 109, 110, Үйлдвэр, 105, 106, 35 кВ-ын Холбоо-А, Б ЦДАШ-ын хамгаалалтын зурвас зөрчин үйл ажиллагаа явуулж байгаа Эрдэм транс ХХК, Тэнүүн өлзий ХХК, Гурван шүтээн ХХК-уудад 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдөр “Хамгаалалтын зурвасыг чөлөөлөх тухай” Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч хугацаатай албан шаардлага хүргүүлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд дээрх аж ахуйн нэгжүүд зөрчлөө арилгаагүй, улсын байцаагчийн шийдвэрийг биелүүлээгүй тул УБЦТС ТӨХК-аас дээрх аж ахуйн нэгжүүдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг 2019 оны 07 дугаар сарын 30-ны өдөр түдгэлзүүлсэн. Дээрх байгууллагуудын хүсэлтээр 2019 оны 07 дугаар сарын 31-ний өдөр Улаанбаатар салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер Л.Ариунболд, Б.Батчулуун нар гурван аж ахуйн нэгжид очиж үзлэг шалгалт хийхэд зөрчил арилаагүй байсан тул кадастрын зургийн дагуу хашаагаа татаж, хамгаалалтын зурвасыг чөлөөлсний дараа цахилгаан эрчим хүчний хэрэглээг сэргээхийг мэдэгдсэн.

## АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Техник зохион байгуулалтын ажлын хүрээнд Гео, Умард, Өмнөд, Яармаг, Үйлдвэр дэд станцын 10 кВ, 6 кВ-ын уян шинийн нийт 180 ширхэг тулгуур изоляторыг сольж суурилуулах ажил хийсэн.

Их засварын ажлын хүрээнд 220/110 кВ ИХБ-4-ийн 220 кВ-ын ТойСШ-1,2-н порталын их засварын ажил хийж гүйцэтгэсэн.



220/110 кВ-ын ИХБ-4-ийн 220 кВ III, IV-р СШ-д их засварын ажил хийж гүйцэтгэсэн.



Цахилгаан дамжуулах агаарын шугам 117-ын их засварын ажлын хүрээнд тулгуур №216-324 хооронд бүх тулгуурыг мөнгөн бронзоор будсан. Нийт 111 ширхэг тулгуур будсанаас тулгуур 21 ширхэг, дундын төмөр тулгуур 35 ширхэг, дундын төмөр бетон тулгуур 55 ширхэг тус тус будсан.



ИХБ-3-ын Т-1, Т-2 трансформаторын 35 кВ-ын ТТ, ТрС, ШинС-1, 2-д демонтаж хийж, шинээр суурилуулсан ЯЗВ хайрцагт вакуум таслуур, ТрС-н ШинС-1-д хуурай салгуурын кабель татаж холболт хийв. Удирдлагаар хуурай салгуур болон вакуум таслуурыг тасалж залгаж шалгасан. Мөн шинээр суурилуулсан гүйдлийн трансформатор руу кабель татаж хоёрдогч хэлхээний холболт хийсэн.



Хүчит шонхор дэд станцын Т-1, 2 болон 110 кВ-ын АШ-109, 110, 149, 150-н аналог болон тоон утгын төлөвийг НМИ системд оруулах тохируулах, турших ажлыг гүйцэтгэж, Т-1, 2 110 кВ-ын ХТ-1,2 10 кВ-ын I, II секцийн тоноглолд СХТ, ДХТ-1,2 хүчдэл дор залгах сэлгэн залгалтад реле хамгаалалтын хэлхээг шалгах схем хөөх ажлын бэлэн байдалд хяналт тавьж ажилласан. 110 кВ болон 10 кВ-ын хүчдэлийн хэлхээн дэх схемийн



зөрүүг хэвийн болгосон. Шонхор дэд станцад 1МВт ачаалал өгч хамгаалалтуудад хэмжилт хийн хэвийн схемд оруулсан.

Бүх дэд станцуудын хашааны гадна болон дотор зэрлэг өвсийг хадаж, ачуулсан.




## ЦАГ ҮЕИЙН АЖЛААР

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх компанийн 220/110/35 кВ-ын Сонгино дэд станц, 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, Зайсан-Сонгино 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил болон 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл

ажлын явцтай танилцаж, ажлаа цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэхийг сануулж “Сонгино” дэд станц, “Их тойрог” төслийн цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлыг эрчимжүүлж, яаралтай ашиглалтад оруулахад анхаарч ажиллахыг үүрэг болгосон.

Улаанбаатар салбарын дотоод ажил  
хариуцсан мэргэжилтэн Ц.Хүрэлбаатар



## ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

### ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын нийт 18 дэд станцад ажлын байрны аюулыг илрүүлэх үзлэг хийж үр дүнг нэгтгэн нийт 175 аюулыг тодорхойлж, эрсдлийг үнэлэн салбарын дарга, ерөнхий инженер, албадын дарга нарт хүлээлгэн өгсөн.

2019 оны хөдөлмөр хамгааллын норм хангалтаар 146 ажилтанд зуны ажлын хувцас, 109 ажилтанд зуны ажлын гутал олгож, 18 дэд станцад эм хэрэгслийн нөхөн хангалт хийсэн.

220/110/35 кВ-ын Дархан дэд станцын 35 кВ-ын реактор, таслуур, реле хамгаалалт автоматикийн байгууламжийг шинэчлэх Эрчим elektrik ХХК, Бурхант, Давхар дэд станцын цэвэр, бохир усны шугам татах Ноён өндөр ХХК, Баясгалант дэд станцын оператив тэжээл үүсгэгчийг шинэчлэх Ричвелл инженеринг ХХК, Үйлдвэр дэд станцын ЗРУ 6 кВ-ын өргөтгөлийн ажил гүйцэтгэх Дархан хэрлэн ХХК-уудад дэд станц хамгаалалтын зурваст ажил гүйцэтгэх зөвшөөрөл олгож бригадын гишүүдэд урьдчилсан зааварчилгаа өгч ажилласан.

Баруунхараа дэд станцын хүчний трансформатор гэмтсэн шалтгааныг судалсан акт, Сүхбаатар дэд станцын 35 кВ-ын Шаамар агаарын шугамын таслуурын гэмтлийг судалсан актуудыг судлан бүртгэсэн.

2019 оны 2 дугаар улирлын ажлын байрны 3 дугаар шатны үзлэгээр илэрсэн зөрчлийн мөрөөр хэрэгжүүлсэн ажлын тайлан, дүн мэдээг нэгтгэсэн. Үзлэгээр нийт 105 зөрчил илэрснээс 79 зөрчлийг бүрэн арилгаж 78,9% гүйцэтгэлтэй байна.

Салбарын ажилтнуудын ХАБЭА-н ажлын оролцоо идэвхийг сайжруулах зорилгоор ХАБЭА талаар зохиож байгаа ажилд идэвхтэй оролцсон ажилтнуудыг эх орны байгалийн үзэсгэлэнт газруудаар аялуулах ажлыг 2019 оны 07 дугаар сарын 27-ны өдрөөс 08 дугаар сарын 08-ны өдрүүдэд зохион байгууллаа.



### АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

110/35/6 кВ-ын Хөтөл дэд станцын Т1, 2 трансформатор болон 35, 6 кВ -ын секц холбогч таслууруудын реле хамгаалалт автоматикийн байгууламжийг SEL фермийн микропроцессорын реле хамгаалалтаар бүрэн шинэчлэх ТЗБАХ-ний ажлыг реле хамгаалалт автоматик, хэмжилт, туршилтын албаны бригад батлагдсан схем зургийн дагуу чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэсэн. Энэ ажлын хүрээнд ажиллагаанаас гарсан нийт 15 панель буулгаж ДХТ1, 2-н 0,4 кВ-ын панелиудыг шилжүүлэх, 35 кВ-ын тоолууруудыг нэг панельд төвлөрүүлэх ажил хийгдсэн.



2019 оны ТЗБАХ-ний ажлын хүрээнд 220/110/35 кВ-ын Дархан дэд станцад хяналтын 42 ширхэг камер бүхий систем суурилуулах ажлыг 8 хүний бүрэлдхүүнтэй бригад хийж гүйцэтгэсэн.

Тухайн ажил нь Үндэсний аюулгүй байдлын газраас өгсөн зөвлөмжийн дагуу Төв удирдлагын шийдвэрээр хийгдсэн салбарын хэмжээний томоохон бүтээн байгуулалтын ажлын нэг болж байгаагаараа онцлог юм. Тухайн дэд станц нь бүрэн камерийн системд шилжсэнээр дотоод, гадаад хяналт шалгалт сайжирч тоноглолын аюулгүй байдал гадны хүчин зүйлийн нөлөөгөөр үүссэн гэнэтийн осол аваарын үеийн зураг, бичлэг, дата мэдээллийг бүрэн хадгалж байгаа нь станцын хувьд шинэ дэвшил болж байна.

Батлагдсан график төлөвлөгөөний дагуу 2019 оны 7, 8 дугаар сард шугам тоноглолын нийт 8 нэр төрлийн ТЗБАХ, их засвар, урсгал засварын ажил, 4 агаарын шугамд эргүүл үзлэг, төлөвлөгөөт бус гэмтэл устгалтын 10 нэр төрлийн ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Баруунхараа дэд станцын гэмтсэн ТМТН-6300/110-У1 маркийн трансформаторыг буулгаж, ТМТН-6300/110 маркийн трансформатораар сольж бүх холболтуудыг хийж хүчдэлд залгасан.



- 220/110/35 кВ-ын Дархан дэд станц дээр 35 кВ-ын Р-1, 2 солих ажлаар Р-2-н элегаз таслуурыг буулгаж вакуум таслуураар сольж, Р-1-ийн тосон таслуур буулгах ажил хийгдсэн.

110 кВ-ын Ерөө-Бугант агаарын шугамд эргүүл үзлэг хийж, 4 ширхэг элемент цохигдсон гэмтэл, 12 тулгуурт шувууны үүртэй байсныг илрүүлсэн. Мөн 110 кВ-ын 114, 115, 116-р агаарын шугам, 220 кВ-ын 208-р агаарын шугамын ээлжит бус үзлэг хийж, 4 ширхэг элемент хагархай, 2 ширхэг элемент нэвт цохигдсон, утас тохогдсон зэрэг зөрчлүүдийг илрүүлсэн. 220 кВ-ын 208-р агаарын шугамын тасралтын дараах ээлжит бус үзлэг хийж, Т329-ийн С фаз дээд доод элемент нэвт цохигдсоныг герландаар нь сольсон.



110/35/10 кВ-ын Борнуур дэд станцын 10 кВ-ын яч №21 ХТ-2 гэмтэж, НОЛ-10 маркийн хүчдэлийн трансформаторыг буулгаж тэргэнцэр болон үүрэн дэх цэвэрлэгээнүүдийг хийж, НТМИ-10 маркийн хүчдэлийн трансформатороо сольж



хэмжилт хийж хэвийн болгосон.

220 кВ-ын 257, 258-р агаарын шугамын нийт уртын дагуу тулгуур №694-403 хүртэл, 110 кВ-ын Сүхбаатар агаарын шугамын тулгуур №380-1 хүртэл координат цэгийг тодорхойлох ажлыг хийж, улсын бүртгэлд оруулах ажлыг тусгай эрх бүхий байгууллага болох Гео инженеринг ХХК-тай хамтарч хийж гүйцэтгэсэн.

### ЦАГ ҮЕИЙН АЖЛААР

Салбарын хамт олон “Эрчим хүчний ажилтны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлж, эрчим хүчний салбарт олон жил, үр бүтээлтэй ажиллаж байгаа Дулаанхаан дэд станцын ээлжийн техникч Б.Болормаа, Хөтөл дэд станцын ээлжийн монтер Л.Чинбат, 110 кВ-ын ХХБ-ийн ээлжийн монтер Д.Мөнхбаасан нар “Эрчим хүчний тэргүүний ажилтан тэмдэг”-ээр, 110 кВ-ын ХХБ-

ийн ээлжийн инженер Д.Эрдэнэбат, Бурхант дэд станцын ээлжийн техникч Г.Пүрэвням, Давхар дэд станцын ээлжийн техникч Ц.Ганболор, Бурхант дэд станцын ээлжийн монтер Ш.Бадрах-Алдар, тусгай тоноглолтой автомашины жолооч С.Лхагвадаржаа нар Эрчим хүчний яамны “Хүндэт жуух бичиг”-ээр шагнагдсаныг салбарын

удирдлагууд гардуулж баяр хүргэлээ.


Мөн эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажилласан автын механик Б.Баяр, засварын ахлах инженер Х.Нямбаяр, засварын монтер Б.Сүхчулуун, С.Батмөнх, реле хамгаалалт автоматикийн инженер Б.Батням нарыг мөнгөн

шагналаар шагнаж урамшуулсан.

Эрчим хүчний ажилтны өдрийн арга хэмжээний үеэр ажилтнуудын дунд хүчит бөхийн барилдаан, караоке, сурын харвааны тэмцээнүүд амжилттай зохион байгууллаа.



Төвийн бүсийн салбарын компьютерийн инженер Н.Оюунболд



## ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

## ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын 45 ажилтанд ажлын байрны анхан шатны зааварчилгааг, 2619 ажилтанд өдөр тутмын зааварчилгааг, 201 ажилтанд сар бүрийн ээлжит зааварчилгааг, 100 ажилтанд ээлжит бус зааварчилгааг, ажил гүйцэтгэх бригадуудын 911 ажилтанд тухайлсан зааварчилгааг өгч ажилласан. Салбарын алба, хэсэг, дэд станцууд дээр аваар эсэргүүцэх дасгал 7 удаа хийгдэж 73 ажилтан, гал эсэргүүцэх дасгал 5 удаа хийгдэж 51 ажилтан, осол эсэргүүцэх дасгал 4 удаа хийгдэж 44 ажилтан тус тус хамрагдсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг давхардсан тоогоор 71 удаа хийж 147 зөрчил, II шатны үзлэгийг 17 удаа хийж 55 зөрчил, III шатны үзлэгийг 2 удаа хийж

21 зөрчлийг илрүүлэн устгах арга хэмжээг авч ажиллалаа.

Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг 29 удаа хийж 21 зөрчлийг илрүүлэн устгалаа. Салбарын харъяа дэд станцуудын өвс ургамлыг хадах, цэвэрлэх ажлууд хийгдэж байна.

Сэрэмжлүүлэг мэдээлэл-даалгаврын мөрөөр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Салбарын ажилтнуудад сэрэмжлүүлэг даалгаврыг танилцуулан ярилцлага хийж, ээлжит бус зааварчилгааг өгч, ажлын байруудад байрлуулсан.

- Ажлын аюулгүй байдлыг хариуцагч нараас бригадын гишүүдэд тавих хяналтыг сайжруулж ажиллахын зэрэгцээ ажлын байрны хяналт

шалгалтыг тогтмол хийж, илэрсэн зөрчлүүдийг тухай бүр устгуулж ажилласан.

- Ажлын байруудын цахилгаан холболтуудын бүрэн бүтэн байдал, дотоод хэрэгцээний тэжээлийн кабель, холболт, монтажийн хийц хэсэгт үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчлийг тухай бүр устгасан.

- Эрдэнэт дэд станцын хуучин аккумуляторын өрөөний агааржуулагчид ашиглаж байсан хоолойг буулгаж монтажийг цэгцэлсэн.

- Эрдэнэт дэд станцын 0,4 кВ-ын тоноглолд үзлэг хийж, илэрсэн зөрчлүүдийг бүрэн устгасан.

- Булган, Хишиг-Өндөр дэд станцын ажлын байрны хүн болон автомашин нэвтрэх хаалга, хашааны цоож түгжээний бүрэн бүтэн байдалд

үзлэг хийж, хоёр ширхэг цоожийг шинээр сольж зөрчлийг устгасан.

- Удирдах ажилтнуудын зөвшөөрөл, шийдвэргүйгээр ажлын байранд дур мэдэн ажил гүйцэтгэхгүй байх талаар ээлжит бус зааварчилгаа өгч, хяналтыг тогтмол тавьж ажилласан.

- Дэд станцуудад суурилагдсан камерийн ажиллагаанд ээлжит бус шалгалт хийж, бичлэгийг шалгасан.

Салбарын төв дээр шинэ баригдсан харуулын өрөөнд салбарын IP камеруудын холболтыг хийж, мэдээллийг дэлгэцээр хардаг болгосон.

## АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Булган, Хархорин, Арвайхээр, Баянтээг дэд станцын 35-110 кВ-ын ИХБ-ийн шкафуудад цэвэрлэгээ үйлчилгээ хийж, битүүмжлэлийг сайжруулах, Баянхонгор дэд станцын Т-1,2, ДХТ-1,2 трансформаторуудад цэвэрлэгээ, үйлчилгээ хийх, Арвайхээр дэд станцад дэлхийн банкны төслөөр таслуур солих ажлын хүрээнд геодизийн хэмжилт хийх, Булган, Хишиг-Өндөр дэд станцад хэсэгчилсэн хэмжилт туршилт хийх, 35 кВ-ын Очистный-А, Б шугамын АВР-ын хэлхээ шалгах, Эрдэнэт дэд станцын Блок-3 шугамын реле хамгаалалт, автоматикийг микропроцессорт

релегээр сольж шинэчлэх, Эрдэнэт дэд станцын цэвэр усны шугамыг солих ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн.

Мөн Реле хамгаалалт автоматик, хэмжилт, туршилтын алба 201, 202-р шугамын газардуулгын эсэргүүцэл хэмжих, Алтай Улиастайн эрчим хүчний системд шинээр 110 кВ-ын хүчдэлийн трансформатор суурилуулж, хоёрдогч хэлхээний холболтыг хийх, Сансар дэд станцын 35 кВ-ын Бүрдийн шугамын SEL-751А реле шинээр суурилуулах, Мөрөн дэд станцын ЗРУ-6 кВ-ын II секцийн реле хамгаалалт автоматикийн их засвар, 110 кВ-ын ХТ-1,2-ын реле хамгаалалт автоматик,

Ил хуваарилах байгууламжийн цахилгаан соронзон хоригийн хэлхээний засвар, Тосонцэнгэл дэд станцын ДХТ-1-ийн реле хамгаалалт автоматикийн засвар, Баянтээг дэд станцын Т-1-ийн гэмтлийг устгаж, трансформаторын иж бүрэн туршилт, Эрдэнэт дэд станцад 200 мВА чадлын АТ-1 автотрансформатораас тосны сорьц авч, хромотографийн шинжилгээ хийх, Булган дэд станцад Т-1, 2 болон 35 кВ-ын ХТ-1 болон ХТ-2, ДТХ-1,2-д өндөр хүчдэлийн туршилт хийх, Хишиг-Өндөр дэд станцад Т-1, 35 кВ-ын ХТ-1, ДТХ-1 трансформаторуудад өндөр хүчдэлийн туршилт хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.



## ЦАГ ҮЕИЙН АЖЛААР

Салбарын хэмжээнд “Ажлын байрны соёл-5С” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тохижилтийн ажлууд хийгдэж, өнгө үзэмж нэмсээр байгаа бөгөөд контор-2-ын гадна пасадны будгийн ажил, автомашины гарааж-1-ийн барилгын засварын ажил, харуулын байрыг шинэчлэх ажлуудыг хийлээ. Эдгээр ажлуудыг гүйцэтгэхэд Засварын албаны монтёр А.Сэр-Од, Б.Батзориг, Захиргаа, аж ахуйн албаны жолооч Ц.Шинэ-Аварга, С.Баттөр, Ж.Отгонбаатар нар идэвх санаачилгатай ажилласан юм.



Салбарын Эрдэнэтийн хэсгийн хамт олон “Эрчим хүчний ажилтны өдөр”-ийг 2019 оны 08 дугаар сарын 16-ны өдөр “Даваат өргөө” амралтын газар өргөн тэмдэглэлээ. Баярын үйл ажиллагааг нээж, салбарын дарга П.Баясгалан үг хэлэхдээ цахилгаан эрчим хүч дамжуулах төлөвлөгөөг давуулан биелүүлж, тоноглолын найдвартай ажиллагааг ханган ажиллахад салбарын ажилтнууд идэвх зүтгэлтэй ажиллаж байгааг тэмдэглэлээ.

Арга хэмжээний үеэр ажлын амжилтаараа хамт олноо хошуучлан ажилласан Захиргаа, аж ахуйн албаны тогооч Ж.Ариунжаргал, өндөр хүчдэлийн туршилтын инженер Б.Батхүү, шугамын засварын монтёр Б.Батзориг, Мөрөн дэд станцын ээлжийн техникч А.Батбаяр, Булган дэд станцын ашиглалтын инженер Б.Батцогоо, Баянхонгор дэд станцын ашиглалтын инженер П.Сүхбаатар, дэд станцын ээлжийн техникч Т.Мөнхзаяа, Арвайхээр дэд станцын ээлжийн монтёр Г.Эрдэнэбаяр, Хархорины хэсгийн ээлжийн техникч А.Даваасүрэн нарыг мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.



Баяраар хүчит 24 бөх барилдснаас шугамын засварын монтёр, сумын заан Д.Болдбаатар түрүүлж, Хялганат дэд станцын ээлжийн монтёр, сумын начин С.Бат-Эрдэнэ үзүүрлэв. Мөн олс таталт, волейболын тэмцээн зохион байгуулж, олс



таталтын тэмцээнд Захиргаа, аж ахуйн албаны баг, волейболын тэмцээнд Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны баг тус тус түрүүлээ.


2004 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр 292 км урт 110 кВ-ын Мөрөн ЦДАШ, 110/35/6 кВ-ын Мөрөн, 110/10 кВ-ын Тосонцэнгэл дэд станцыг



ашиглалтад хүлээн авч, Хөвсгөл аймгийн төв суурин газруудыг тэжээж эхэлснээс хойш 15 жил өнгөрч, энэ хугацаанд 800 сая.кВт.цаг гаруй цахилгаан эрчим хүч түгээж, Алтай Улиастайн эрчим хүчний системтэй холбогдсон томоохон зангилаа станц болтлоо өргөжсөн байна.

Цахилгаан эрчим хүчийг тасралтгүй, найдвартай дамжуулах үүргээ нэр төртэй биелүүлж байгаа Мөрөн дэд станцын хамт олондоо 15 жилийн ойн баярын мэнд хүргэж, эрүүл энх, ажлын амжилт хүсэн ерөөе.

Хангайн бүсийн салбарын сургалт, бүтээмжийн инженер Ж.Мандахбаяр



## ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

### ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

2019 оны 8 дугаар сард урьдчилсан зааварчилгаанд 29 ажилтан, сарын давтан зааварчилгаанд 137 ажилтан, ээлжит бус зааварчилгаанд 301 ажилтан, өдөр тутмын давтан зааварчилгаанд 1607 ажилтан давхардсан тоогоор хамрагдаж ажилласан.

Салбарын хэмжээнд аваар эсэргүүцэх дасгалыг 3 удаа зохион байгуулж 34 ажилтан, галын аюулаас урьдчилан сэргийлэх дасгал

2 удаа зохион байгуулж 34 ажилтан, анхны тусламж үзүүлэх дасгал 4 удаа зохион байгуулж 50 ажилтан хамрагдан аюул ослоос урьдчилан сэргийлж ажилласан.

Салбарын хэмжээнд дэд станцуудын цахилгаан тоног төхөөрөмжүүд, цахилгаан дамжуулах агаарын шугамд хийгдэх төлөвлөгөөт их болон урсгал засвар, гэмтэл устгалтын ажлаар

аюулгүй ажиллагааны нарыдаар 116 ажил, шийдвэрээр 41 ажил хийгдсэн.

Компаниас ирүүлсэн сэрэмжлүүлэх мэдээлэл даалгавар №1-ийн мөрөөр ажил зохион байгуулж, тайланг Хяналт мониторингийн хэлтэст хүргүүлсэн.

207-р агаарын шугамын тасралтаар хийгдсэн ажлуудад аюулгүй ажиллагааг хангаж ажиллах

талаар ээлжит бус зааварчилгаа өгч, Мандалговь 110 кВ-ын агаарын шугамд TBEI төслөөр хийгдэж байгаа их засварын ажлуудад хяналт тавьж ажилласан.

Шинээр ажилд орсон 8 ажилтан, ажлын байр өөрчлөгдөж байгаа 1 ажилтнаас мэргэжлийн шалгалт авч, Мэргэжлийн шалгалтын комиссоор шийдвэр гаргуулж ажилласан.

### АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Засварын төлөвлөгөөт ажлын хүрээнд урсгал засвараар Багануур дэд станцын 35 кВ-ын Р-2 тосон таслуурт тохируулга хийж реле хамгаалалт автоматик шалгах, Чойр дэд станцын АТ-1, 2-ын 35 кВ-ын тосон таслуур, АТ-1, 2-ын 35 кВ-ын ТРС, АТ-1-ийн 35 кВ-ын ШинС салгууруудад тохируулга хийх, Чойр дэд станцын Нисэх 35

кВ-ын таслуурын реле хамгаалалт автоматик, 35 кВ-ын Р-1, 2 вакуум таслуурын засвар үйлчилгээ, Сайншанд дэд станцын ЯЧ№18, 23 10 кВ-ын тосон таслуурыг вакуум таслуураар солих зэрэг ажлууд хийгдсэн.

Их засварын ажлаар Багануур дэд станц 35 кВ-ын Р-1 тосон таслуурын тохируулга хэмжилт



туршилтын ажил хийсэн.

Ашиглалтын түвшин дээшлүүлэх ажлаар Багануур дэд станцын АТ-1, 2-ын засвар үйлчилгээ, Хот, Төв, Бор-өндөр, Баянмөнх,

Өндөрхаан дэд станцуудын трансформаторуудад засвар үйлчилгээ, Сайншанд, Бор-Өндөр 110 кВ-ын Т-1, 2 трансформаторын оруулга хэмжих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

### ЦАГ ҮЕИЙН АЖЛААР

Манай салбар 2019 оны 8 дугаар сарын 17-ны өдөр Эрчим хүчний ажилтны баярын өдрийг “Бүрэг Эрэг” амралтын газар зохион байгуулж, баярын үйл ажиллагааг нээн салбарын дарга Н.Мөнгөнхөлөгт, ерөнхий инженер Б.Түвшинбаяр нар үг хэлж, баяр хүргэлээ.

Ажил үйлсээрээ хамт олноо хошуучлан ажилласан Замын-Үүд дэд станцын ээлжийн техникч Г.Цэцэгдэлгэр “Эрчим хүчний тэргүүний ажилтан” тэмдгээр, Чойр дэд станцын ээлжийн инженер Ч.Жаргалсайхан, ээлжийн техникч Н.Энхжаргал, Сайншанд дэд станцын ээлжийн монтёр Б.Цэцэгдэлгэр, Замын-Үүд дэд станцын реле хамгаалалт автоматикийн инженер Г.Батзаяа, ээлжийн техникч Б.Энхцацрал нар Эрчим хүчний яамны “Хүндэт жуух бичиг”-ээр шагнагдсаныг салбарын удирдлагууд гардуулж баяр хүргэлээ.



Сайншанд дэд станцын ээлжийн монтёр Б.Цэцэгдэлгэр

Мөн эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажилласан Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны ээлжийн техникч Г.Батцэнгэл, Санхүү, эдийн засгийн албаны хөрөнгийн нягтлан бодогч Г.Энхтүвшин, Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны дарга Б.Ганбаатар, Багануур дэд станцын ээлжийн инженер Л.Сарангэрэл, Төв дэд станцын ээлжийн техникч И.Оюунцэцэг, Хот дэд станцын ээлжийн техникч Н.Урантогос, Захиргаа, аж ахуйн албаны жолооч Ц.Батмөнх, Н.Мөнхгэрэл, жижүүр сантехникч Ж.Мөнхбат, засварын монтёр Б.Пүрэвзэ, Б.Бат-Амгалан, Реле хамгаалалт автоматик, хэмжилт, туршилтын албаны туршилтын инженер Э.Цог, Чойр хэсгийн дарга Б.Туяа, жолооч Д.Гансэлэм, Өндөрхаан дэд станцын ээлжийн техникч Х.Одсайхан, Сайншанд дэд станцын ээлжийн инженер Б.Мөнхжаргал,

Бор-Өндөр дэд станцын ээлжийн техникч Э.Отгонбаяр, Айраг дэд станцын ээлжийн монтёр М.Соронзонболд, Борхой дэд станцын ээлжийн монтёр М.Гантогтох нарыг мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.

Баярын арга хэмжээний үеэр ажилтнуудын дунд хөгжөөнт буухиа тэмцээн, үндэсний бөхийн барилдаан зохион байгуулсан.

Энэ жилээс эхлэн үндэсний бөхийн тэмцээнийг шилжин явах цомтой болгосон. Бөхийн барилдаанд жолооч, сумын заан Д.Бямбаа түрүүлж, ээлжийн техникч С.Зоригтбаатар үзүүлэлээ.


Чойр, Айраг дэд станцын хамт олон хамтран эрчим хүний ажилтны баярыг Говьсүмбэр аймгийн “Цоорхойн рашаан” гэдэг газар зохион байгуулж, ахмадуудаа урин сайхан баярлалаа.



Замын-Үүд дэд станцын ээлжийн техникч Г.Цэцэгдэлгэр



Зүүн-Өмнөд бүсийн салбарын мэдээлэл технологийн инженер Б.Батням



## ГОВИЙН БҮСИЙН САЛБАР

## ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд 2019 оны 07, 08 дугаар сард нарыаар 40, шийдвэрээр 63 ажил хийгдсэн. Наряд шийдвэрээр ажил гүйцэтгэхэд ажлын аюулгүй байдлыг хариуцагчид болон бригадын бүрэлдэхүүнд онцгой анхааран, шат шатны зааварчилгааг чанартай өгч, хяналт тавьж ажилласан.

Нийт 8 удаагийн дасгал зохион байгуулагдаж 76 ажилтанд, сарын давтан зааварчилгааг 126 ажилтанд, тухайлсан зааварчилгааг 988 ажилтанд, ээлжит бус зааварчилгааг 1798 ажилтанд тус тус өгч ажилласан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг давхардсан тоогоор 466

удаа хийж 19 зөрчил, II шатны үзлэгийг 13 удаа хийж 8 зөрчил илрүүлэн устгаж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч ажилласан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг 132 удаа хийж 21 зөрчил илрүүлэн, зөрчлийг устгах үүрэг даалгавар өгч хяналт тавин ажиллаж байна.

Салбарт 2019 оны 05-08 дугаар сарын хооронд шинээр ажилд орсон 16 ажилтанд

дагалдан суралцах хөтөлбөр олгож багш шавийн гэрээ байгуулан ажилласан. Эдгээр дагалдан ажилтнуудад албадын дарга, инженерүүд ажлын байрны сургалтыг зохион байгуулж дагалдан суралцах хөтөлбөр авсан 8 ажилтан мэдлэгийн шалгалтаа амжилттай өгч жинхлэн ажиллаж байна.

## АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

110 кВ-ын Тавантолгой-Даланзадгад агаарын шугамын их засварын ажлыг 2019 оны 07 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд автовышка-1, автокран-2, үйлчилгээний машин-1 нийт 15 ажилтны бүрэлдэхүүнтэй бригад хийж гүйцэтгэсэн. Тус ажлын хүрээнд тулгуур №312-283, 155-132, 130-35, 34-2 хооронд нийт 138 тулгуурт фаз тус бүрт 414 ширхэг аэродинамик элементээр сольж, тулгуур №224-ийн 2-р фазад 2 судал, тулгуур №228-229-ийн голд 2-р фазад судал, тулгуур №39-ийн 2-р фазад 8 ширхэг судал тасарсныг ресс шахаж гэмтлийг устгасан.



110/35/10 кВ-ын Мандалговь дэд станцын 10000 кВА Т-1 трансформаторыг 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдөр 16000 кВА нөөц трансформатороор сольж Улаанбаатар хот руу засварт явуулах ажлыг гүйцэтгэсэн. 2019 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 04:00-23:00 цагийн хооронд 16000 кВА нөөц трансформаторыг ажлаас чөлөөлж, засвараас ирсэн 10000 кВА Т-1 трансформаторыг ажилд оруулах туршилт хэмжилт хийх ажлыг 1 авто кран, 2 ачааны автомашин, 23 ажилтны бүрэлдэхүүнтэй бригад хийж гүйцэтгэсэн.



Тавантолгой дэд станцад 2019 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 05:06-14:15 цагийн хооронд

нэг автокран, 5 ажилтны бүрэлдэхүүнтэй бригад 110 кВ-ын Даланзадгад агаарын шугамын үндсэн хамгаалалтыг ажилд оруулах бэлтгэл ажлын хүрээнд 1 ширхэг УСО босгож, "А" фазад холбооны конденсатор суурилуулж холболт хийсэн, УСО-нд газардуулгын буулт гагнаж станцын хүрээ газардуулгад холбосон.

110 кВ-ын Тавантолгой-Даланзадгад агаарын шугам 2019 оны 08 дугаар сарын 25-ны өдөр хамгаалалтаар тасарч, тасралтын мөрөөр үзлэг хийсэн. Үзлэгээр тус шугамын трассын дагуу хүнд даацын автомашин, механизм байнга зорчдог тул

цохигдсон элементийг солих ажил хийгдсэн.

Улаанбаатар-Мандалговийн 330 кВ овортой 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ Мандал, Тавантолгой, Оюутолгой дэд станцын өргөтгөл шинэчлэлтийн барилга угсралтын ажил дуусч байгаатай холбогдуулан салбарын РХАХТА-ны дарга, инженерүүд техникийн комиссын хэмжилт, туршилт, реле хамгаалалтын бригадын бүрэлдэхүүнд 2019 оны 08 дугаар сарын 01-06-ны өдрүүдэд ажилласан.

2019 оны ТЗБАХ-ний ажлаар 110/35/10 кВ-ын Даланзадгад дэд станцын Т-1,2 10 кВ-ын оруулгын SEL-351A релег чиглэл мэдэрдэг SEL-



351S релегээр солих ажлыг 2019 оны 08 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Мөн 110/35/10 кВ-ын Даланзадгад дэд станцын 35 кВ-ын 4 гаргалгааны аналог хэмжүүрүүдийг тоон хэмжүүрээр шинэчлэх, 10 кВ-ын ячейк №8, 14-т чадлын чиглэл заадаг хэмжүүр тус тус суурилуулсан.

## ЦАГ ҮЕИЙН АЖЛААР

Компанийн Гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу 2019 оны 07 дугаар сарын 29-ний өдөр салбарын оффиссын барилгын ажлын явцтай танилцаж, гүйцэтгэгч компанийн удирдлагуудтай уулзалт хийж, барилгыг 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүлээлгэн өгөх үүрэг даалгавар өгөгдсөн ба барилгын дулааны шугам сүлжээ, гадна фасад, гадна тохижилтын ажил хийгдэж байна.

Дундговь аймгийн байгалийн цогцолбор

газар Их газрын чулууны уулын задгай театрт 2019 оны 08 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан 3000 уртын дууч, морин хуурчдын "Уяхан замбуутивийн наран" урлагийн тоглолтод салбарыг төлөөлж автын механик Б.Түвдэндорж, сургалт бүтээмжийн инженер Ц.Батсүх, нярав М.Цэрэндэжид, ээлжийн монтер Б.Түмэннаст, ээлжийн инженер Г.Содномцэрэн, реле хамгаалалт автоматикийн монтер Д.Наваанжаргал нар ая дуугаа өргөн амжилттай оролцсон.




Эрчим хүчний ажилтны өдрийг тохиолдуулан баярын хүндэтгэлийн хурлыг Дундговь аймгийн төвд зохион байгуулж, идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа ажилтнуудыг шагнаж урамшуулсан. Мөн салбарын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос тогтвор суурьшилтай ажиллаж байгаа 11 ажилтныг Улаан-Үүд-Итгэлт хамбын 4 өдөр 4 шөнийн аялалд

явах эрхийн бичгээр шагнав. Эрчим хүчний ажилтны өдрийг 2019 оны 08 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Хар зүрхний хөх нуурын байгалийн үзэсгэлэнт газарт тэмдэглэн өнгөрүүлж, бэсрэг наадмын үндэсний бөхийн барилдааны түрүү бөхөөр засварын монтер М.Даваадорж шалгарч, ээлжийн монтер Г.Нарангэрэл үзүүлэсэн.



Говийн бүсийн салбарын хүний нөөцийн мэргэжилтэн Ц.Ганнягат



# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ АЛБАН ТОМИЛОЛТООР ДЭД СТАНЦУУДАД АЖИЛЛАЛАА

Компанийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу, Хяналт мониторингийн хэлтсийн дарга Я.Мөнхтөр нар Хангайн бүсийн салбар, Төвийн бүсийн салбарын зарим дэд станцуудын ашиглалтын байдал, их засварын болон ТЗБАХ, хөрөнгө оруулалтаар салбарт хийгдсэн ажлын явцтай танилцах, үнэлэлт дүгнэлт өгөх, тулгамдаж байгаа асуудлыг газар дээр нь шийдвэрлэх зорилгоор 2019 оны 08 дугаар сарын 05-11-ний өдрүүдэд албан томилолтоор ажиллалаа.

Томилотын хугацаанд Хангайн бүсийн салбарын Булган, Мөрөн, Тосонцэнгэл, Хялганат, Эрдэнэт, Төвийн бүсийн салбарын Баясгалант, Хөтөл, Орхон, Дулаанхан, Сүхбаатар, Ерөө, Бугант, Толгойт, Шарын гол, Зүүнхараа,

Баруунхараа, Борнуур зэрэг 17 дэд станцын ашиглалтын байдалтай танилцахын зэрэгцээ компанийн хэмжээнд 2018-2019 онд хийгдсэн томоохон ажил, хүрсэн амжилтыг танилцуулан, аюулгүй ажиллагааг хангаж, хариуцлагатай ажиллахыг уриалж, шуурхай ажиллагааны ажилтнуудын санал хүсэлтийг сонсож, зарим асуудлыг газар дээр нь шийдвэрлэж ажиллалаа.

Мөн 110 кВ-ын Мөрөн цахилгаан дамжуулах агаарын шугамын 456-466 тулгуурын хооронд дроноор үзлэг хийж, тасралтын шалтгаан, гэмтлийн төлөв байдалд нарийвчилсан үзлэг шалгалтыг явуулсан юм.

ХМХ-ийн дарга Я.Мөнхтөр



## СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ


“Өндөр давтамжийн ПВЗУ-Е постын хэрэглээ, Монголын эрчим хүчний системд ашиглагдаж буй ПВЗУ-Е төхөөрөмжийг тохируулах” сэдвээр 2019 оны 08 дугаар сарын 29-ний өдөр Монхорус интернэшнл ХХК-аас сургалт зохион байгуулагдаж, компанийн болон Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн нийт 10 гаруй реле хамгаалалт автоматикийн инженер техникийн ажилтнууд хамрагдсан байна.

Сургалт дараах агуулгатай явагдсан. Үүнд:

- ДЦС-4-ийн ИХБ-ийн хэсэгт байрлах 204-р агаарын шугамын реле хамгаалалтын панельд суурилсан ПВЗУ-Е төхөөрөмжид хэмжилт хийх
- Компанийн Зүүн-Өмнөд бүсийн салбарын Айраг дэд станцад суурилуулахаар төлөвлөж буй хоёр ширхэг ПВЗУ-Е бүхий реле хамгаалалтын иж бүрэн панельд туршилт хийх
- Инженер техникийн ажилтнууд өөрийн салбар нэгжид ашиглагдаж байгаа ПВЗУ-Е төхөөрөмжтэй холбоотой гарч байгаа асуудлууд, ашиглалтын үед хийх хэмжилт болон засварын ажлын тухай заавар, зөвлөмж авах, асуулт хариулт, ярилцлага хийсэн.



Сургалт бүтээмжийн хэлтсийн сургалт, бүтээмжийн инженер Л.Энхжаргал



# “ЭРЧИМ ХҮЧНИЙ АЖИЛТНЫ ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭЭ

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Төв удирдлага, Улаанбаатар салбарын хамт олон 2019 оны 8 дугаар сарын 17-ны өдөр “Мандала” амралтад “Эрчим хүчний ажилтны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлээ.

Баярын арга хэмжээний үеэр эрчим хүчний салбарт олон жил, үр бүтээлтэй ажиллаж байгаа Реле хамгаалалт автоматик, хэмжилт, туршилтын хэлтсийн хэмжүүрийн техникч Ц.Санжаабаатар, Улаанбаатар салбарын шугамын засварын

монтёр М.Мөнгөн-Эрдэнэ, тооцооны нягтлан бодогч Ц.Сувдмаа, ээлжийн инженер Ч.Мандхай нар “Эрчим хүчний тэргүүний ажилтан тэмдэг”-ээр, Улаанбаатар салбарын цалин хөлсний нягтлан бодогч С.Гэрэлмаа, реле хамгаалалт автоматикийн

инженер Б.Тогтохжаргал, ээлжийн инженер М.Золжаргал, Б.Энэбиш, ээлжийн монтёр Ч.Чулуунбат, М.Гэрэлсүрэн, Б.Баярмаа нар Эрчим хүчний яамны “Хүндэт жуух бичиг”-ээр шагнагдсаныг компанийн удирдлагууд гардуулж баяр хүргэлээ.



РХАХТХ-ийн хэмжүүрийн техникч Ц.Санжаабаатар хэлтсийн хамт олонтойгоо



УБС-ын тооцооны нягтлан бодогч Ц.Сувдмаа



УБС-ын ээлжийн монтёр Б.Баярмаа компанийн удирдлагуудын хамт

Баярын үйл ажиллагааны үеэр үндэсний бөхийн барилдаан, хөгжөөнт тэмцээн, үдшийн цэнгүүн тус тус зохион байгуулан ажилтнууд амжилттай оролцож, бөхийн барилдаанд уран мэхээ уралдуулан хүч сорин барилдсанаас Улаанбаатар салбарын ээлжийн монтёр Ч.Эрдэнэбаяр түрүүлж, Улаанбаатар салбарын ээлжийн монтёр 3.Бямбабат үзүүрлэлээ.

1 дүгээр байр, Улаанбаатар салбарын шугамын засварын монтёр Б.Сонор 2 дугаар байр, Улаанбаатар салбарын ээлжийн монтёр Ч.Гантогтох 3 дугаар байр тус тус эзэлж, хамт олноо баярлууллаа.



“Азарганы уралдаан” хөгжөөнт тэмцээн



Зүүн гар талаас: Үзүүрлэсэн УБС-ын ээлжийн монтёр Б.Бямбабат, түрүүлсэн УБС-ын ээлжийн монтёр Ч.Эрдэнэбаяр



“Дааганы уралдаан” хөгжөөнт тэмцээн



“Дааганы уралдаан” хөгжөөнт тэмцээний “Баян ходоод”

“Азарганы уралдаан” хөгжөөнт тэмцээнд Шуурхай зохицуулалтын хэлтсийн диспетчер инженер Н.Бямбадорж 1 дүгээр байр, Төсөл хөтөлбөрийн хэлтсийн төсөл хөтөлбөрийн инженер М.Дуулга 2 дугаар байр, Техникийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн техникийн нөхцөл хариуцсан инженер Б.Пүрэвхүү 3 дугаар байр, “Дааганы уралдаан” хөгжөөнт тэмцээнд Улаанбаатар салбарын ээлжийн монтёр Ч.Ганболд 1 дүгээр байр, Улаанбаатар салбарын диспетчер инженер Б.Даваасамбуу 2 дугаар байр, Улаанбаатар салбарын нийлмэл реле хамгаалалтын инженер Д.Төмөр-Очир 3 дугаар байр, “Сур харваа” хөгжөөнт тэмцээнд Улаанбаатар салбарын ээлжийн инженер Т.Ганзориг



“Сур харваа” хөгжөөнт тэмцээн

Мөн баярын арга хэмжээний үеэр ажилтнуудын дунд азын сугалаа зохион байгуулж, “Азтан” тодруулав.



“Супер азтан” Улаанбаатар салбарын засварын монтёр А.Дашзэвэг Гүйцэтгэх захирлын хамт

Компанийн Төв удирдлагын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос “Эрчим хүчний ажилтны өдөр”-ийн баярын мэндчилгээ дэвшүүлж, үр бүтээлтэй ажиллаж байгаа Мэдээллийн технологийн хэлтсийн программист инженер

шагналаар тус тус шагнаж урамшуулсан. Компанийнхаа нийт хамт олондоо эрүүл энх, аз жаргал, ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.

ЗУХ-ийн мэргэжилтэн  
Т.Аюуш

# МОНГОЛ УЛСЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН ГАВЬЯАТ АЖИЛТАН Н.ТОГООН ХӨШӨӨНД ЦЭЦЭГ ӨРГӨВ

Эрчим хүчний салбарын ууган инженер, Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан Намсрайн Тогоон 95 насны ойг тохиолдуулан хүндэтгэл үзүүлж, түүний хөшөөнд цэцэг өргөх ёслолын арга хэмжээ 2019 оны 08 дугаар сарын 16-ны өдөр болов. Ёслолын ажиллагаанд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн удирдлага, хамт олон, хамтран ажиллаж байсан ахмад ажилтнууд, түүний үр хүүхдүүд хүрэлцэн ирж оролцлоо.

Намсрайн Тогоон нь 1947 оноос хөдөлмөрийн гараагаа Улаанбаатар хотын төв цахилгаан комбинатаас эхэлж, инженер, ерөнхий инженер, станцын дарга, яамны орлогч сайдаар тус тус ажиллаж байсан. 1965 онд Эрчим хүчний удирдах газар байгуулагдахад Аж үйлдвэрийн яамны орлогч сайд бөгөөд Эрчим хүчний удирдах газрын анхны даргаар ажиллаж байсан.

Эрчим хүчний үндэсний ууган инженер, тухайн салбарын туршлагажсан удирдах ажилтан Намсрайн Тогоон нь эх орны төвийн районд томоохон цахилгаан станцууд, цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээг барьж, эрчим хүчний нэгдсэн сүлжээг бий болгох, түүнийг боловсон хүчнээр бэхжүүлэх, үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангаж, үр ашгийг дээшлүүлэх ажлыг биечлэн удирдаж хэрэгжүүлсэн гавьяатай юм. Түүний хөдөлмөр зүтгэлийн гавьяаг үнэлж, алдаршуулан хөшөөг нь хуучин Эрчим хүчний удирдах газар байсан, одоогийн Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн төв байрны өмнө талд босгосон билээ.

ЗУХ-ийн мэргэжилтэн  
Т.Аюуш




## АХМАДУУД АЯЛАВ

Одко тур компанийн хоёр өдөр нэг шөнийн Хэнтий аймгийн Хар зүрхний Хөх нуурын аялалд Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан Д.Жанчив ахлагчтай 15 ахмад настан аяллаа. Аялалд явсан ахмадууд үзэсгэлэнт сайхан байгалийг шүтэн биширч сэтгэл өндөр аялав.

Ахмадын хорооны дарга  
Ц.Уламбаяр



Аялагчид



# ТАМИРЧИД ЧЕЖУ АРЛААР АЯЛЛАА

Монгол Улсад Эрчим хүчний салбар үүсч хөгжсөний 97 жилийн ойг угтан эрчим хүчний салбарын үйлдвэр, компанийн ажилтнуудын дунд зохион байгуулагдсан “Спортын их наадам 2019” тэмцээнд амжилттай оролцож, эрчим хүчний салбарын үйлдвэр компаниудаа тэргүүлэн, үнэмлэхүй “Аварга баг”-аар шалгарч цомын эзэд болсон компанийн баг тамирчдыг компанийн захиргаа БНСУ-ын Чэжү аралд 5 хоног аялах эрхийн бичгээр шагнаж урамшуулсан юм.

Компанийн баг тамирчдын Чэжү арлаар аялах аялал 2019 оны 07 дугаар сарын 23-28-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, Чэжү арлын түүх уламжлал, байгалийн үзэсгэлэнт өвөрмөц тогтоц, техник технологийн дэвшилтэд 5D үзвэр, орчин үеийн урлагийн музей, нууцлаг сүүдрийн бүжгийн тоглолт, Монгол морьтон циркийн үзүүлбэр зэргийг үзэж сонирхохын зэрэгцээ Чэжү арлын уугуул иргэдийн амьдардаг тосгоны хүмүүсийн аж амьдралтай танилцаж, солонгос үндэсний хоол


кимчи хийх, солонгос үндэсний хувцас хамбуг өмсөж зураг даруулах, дэлхийн 7 гайхамшигийг жижигрүүлж хийсэн цэцэрлэгт хүрээлэнгээр зугаалах, Чонжиён хүрхрээ, ЮНЕСКО-ын дэлхийн өвд бүртгэгдсэн сөнөсөн галт уулын тогоо үзэх явган аялал болон задгай далайд моторт завиар аялал хийсэн. Мөн та бүхэндээ сонирхуулахад Солонгосын олон ангит кино “All in” киноны зураг авалт хийсэн Цагаан сүмээр очиж үзсэн боловч сүм маань чихрийн дэлгүүр болсон байлаа.

Компанийн захиргаанаас зохион байгуулсан баг тамирчдын БНСУ-ын Чэжү арлаар хийсэн аялал маш сонирхолтой, хэзээ ч мартагдахгүй дурсамжийг үлдээсэн гайхамшигтай аялал болсон билээ. компанийн удирдлага, хамт олондоо талархал илэрхийлье.

ХМХ-ийн их эмч Э.Ууганцэцэг



## МӨНГӨН МЕДАЛИЙН ЭЗЭН БОЛЛОО



Байт харвааны насанд хүрэгчдийн Улсын аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 08 дугаар сарын 01-04-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдаж, 11 байгууллагын 100 гаруй тамирчин өрсөлдөж, шилдгүүдээ тодруулсан байна.

Уг тэмцээний кампаундын төрөлд манай компанийн Хяналт мониторингийн хэлтсийн сувилагч, Монгол Улсын байт харвааны спортын дэд мастер, “Зэвт Хасар” клубын тамирчин С.Мөнх-Эрдэнэ амжилттай оролцож, дэд байр эзэлж мөнгөн медалийн эзэн боллоо.

Спортын дэд мастер С.Мөнх-Эрдэнэд спортын өндөр амжилт хүсье.

ХМХ-ийн их эмч Э.Ууганцэцэг



ДАМЖУУЛАХ  
Сүлжээ  
ЦАХС ТЕХНИК ХЭВЛЭЛ  
www.damjuulakh.com

Улаанбаатар хот-17060  
Хан-Уул дүүрэг  
Чингисийн өргөн чөлөө-22/1

Утас: 99066861  
Факс: 976-70043287  
Хэвлэлтэд өгсөн: 2019.09.18

Дугаарыг эрхэлсэн: Т.Аюуш  
Хянасан: М.Даваажав

Үнэгүй тараагдана.